Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ

Д/д	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл
1	**Нэр** Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр	Цагаан гэрүүд овогт Бираагийн Одонгэрэл
2	**Хүсэлт гаргагчийн хаяг** Иргэний үнэмлэхэд байгаа хаяг	
3	**Төрсөн огноо** Төрсөн газар	Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сум
4	**Боловсрол** Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, оноог бичнэ.	2016-2020 онд Дотоод хэргийн их сургуульд “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” сэдвээр Хууль зүйн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан. 2009-2011 онд Япон Улсын Кюүшүгийн Их сургуулийн хууль зүйн магистр (LL.M) 2006-2008 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн хууль зүйн магистр 2002- 2004 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эрх зүйн бакалавр 1997-2001 онд МУБИС-ийн Монгол-Англи хэлний бакалавр.
5	**Ажил эрхлэлт** Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.	2019 - одоог хүртэл СИТИ Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирлаар ажиллаж байна. 2005 - одоог хүртэл Монголын Хуульчдын Холбооны гишүүн, хуульч 2005 - одоог хүртэл МӨХ-ний гишүүн, өмгөөлөгч (2015-2019 онд төрийн жинхэнэ алба эрхэлж байсан хугацаанд түр түдгэлзүүлсэн) 2012 - 2018 он Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургуулийн эрх зүйн тэнхимд хагас цагаар багшилж байсан. 2015 - 2019 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Сургалтын хэлтсийн дарга, Хүний нөөцийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах хэлтсийн дарга ажлуудыг гүйцэтгэж байсан. 2005 - 2015 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнд Эрүүгийн эрх зүй, криминологийн секторт эрдэм шинжилгээний ажилтан, бодлогын ахлах судлаачаар ажиллаж байсан.
6	**Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал** Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний	Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн

	алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ.	
7	**Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил** Хүсэлт гаргагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: - албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; - ажлын байрны тодорхойлолт; - удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; - хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.	**1. 2019–одоог хүртэл — СИТИ Их сургууль, Хууль зүйн сургууль** Албан тушаал: Сургуулийн захирал Ажлын газрын хаяг: Сүхбаатар дүүрэг 7р хороо, Денверийн гудамж, Улаанбаатар хот. Ажлын байрны үндсэн чиг үүрэг: Хууль зүйн сургуулийн сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг удирдах, оюутан суралцагчдын сурлагын түвшин, сахилга бат, хүмүүжилд хяналт тавих, сургалтын хөтөлбөрийг шинжлэх ухааны онол, арга зүйн түвшинд боловсруулан хэрэгжүүлэх, багш нарыг эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйд идэвхтэй оролцуулах, багш нарын ажил үүргийн хуваарийг оновчтой тогтоох, хууль зүйн мэргэжлийн хичээл заах, багш нарын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, чиглүүлэх, сургуулийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангах. Удирдах албан тушаалтны нэр: Д.Мөнх-Эрдэнэ /СИТИ Их сургуулийн ТУЗ-ын дарга/ Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан хүний нэр: Д.Булган /Хууль зүйн сургуулийн багш/ **2. 2015-2019 он хүртэл – Шүүхийн ерөнхий зөвлөл** Албан тушаал: Сургалтын хэлтсийн дарга; Хүний нөөцийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч; Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах хэлтсийн дарга Хаяг: Чингэлтэй дүүрэг, 5р хороо, Тасганы овоо, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улаанбаатар хот Ажлын байрны үндсэн чиг үүрэг: А. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Сургалтын хэлтсийн дарга: Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг хэрэгжүүлнэ. Шүүхийн хүний нөөцийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтын хэрэгцээ, үр дүнг тодорхойлж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах. Б. Хүний нөөцийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, шүүгч болон шүүхийн захиргааны ажилтны сонгон шалгаруулалт, томилгоо, шилжилт хөдөлгөөн, мэргэшил, ур чадварын хөгжлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцна. Хүний нөөцийн бүрдүүлэлт, хөдөлмөрийн харилцаа, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлыг зохицуулна. Газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, ажлын үр дүн, хууль ёсны байдлыг хариуцах.

		В. Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах хэлтсийн дарга: Шүүгчийн хараат бус байдал, халдашгүй байдлыг хангах, шүүн таслах ажиллагаанд гадны нөлөөлөл, хууль бус оролцоо үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Шүүгчийн хараат бус байдалд халдсан талаарх мэдээлэл, гомдол, нөлөөллийн мэдүүлэг хүлээн авах, шалгуулах, холбогдох арга хэмжээ авах ажлыг зохицуулна. Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулах, холбогдох байгууллагууд, цагдаагийн байгууллагатай хамтран шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах. Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл: ШЕЗ-ийн Ажлын албаны дарга доктор Т.Мэндсайхан (2015-2018 он) Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан хүний нэр: С.Алтанхуяг, /Сургалтын хэлтсийн референт-2015 он/ Д.Мөнхбат /Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн тамгын дарга-2017 он / **2012–2018 Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургууль (Одоо Идэр Их сургуультай нэгдсэн.)** Албан тушаал: Эрх зүйн тэнхимд 50 хувийн багш Ажлын байрны үндсэн чиг үүрэг Хүний эрх, харьцуулсан эрх зүй, эрүүгийн эрх зүйн чиглэлээр багшилж, Хууль зүйн сургуулийн сургалт, судалгааны үйл ажиллагаанд оролцох. Ажлын газрын хаяг: Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, Оюутны гудамж - 7, Монгол Улс Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл: Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургуулийн захирал Т.Отгон **3. 2005- 2015 Хууль зүйн үндэсний хүрээлэн** Албан тушаал: Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан; бодлогын ахлах судлаач Хаяг: Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо 7 дугаар хороолол /14182/ Алтайн гудамж 841 Ажлын байрны үндсэн чиг үүрэг: Эрүүгийн эрх зүй, криминологи, хүний эрх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон харьцуулсан эрх зүйн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, бодлогын судалгаа, лавлагаа, судлаачийн зөвлөмж зэргийг гүйцэтгэн, бодлого боловсруулагчид зөвлөмж хүргүүлэх. Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл: ХЗҮХ-ийн захирал академич Ж.Амарсанаа Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан хүний нэр: Д.Цэцэгдарь /ХЗҮХ-ийн ажилтан/

8	**Ёс зүй** Доор дурдсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно. - сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх; - сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх.	1. Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх: Б.Одонгэрэл нь сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байгаагүй. 2. Сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх: Б.Одонгэрэл нь сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй.
9	Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд: - үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; - үйл ажиллагааны гол агуулга; - үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; - үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; - хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; - хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.	**1. Албадан хөдөлмөрийн тухай олон улсын зохицуулалтыг Монгол Улсын хууль тогтоомж, бодлоготой харьцуулсан судалгаа гүйцэтгэсэн.** Хугацаа: 2025 он Эрхэлсэн газар: Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ/ILO) захиалгаар Үйл ажиллагааны гол агуулга: Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны конвенцын 2014 оны протоколыг Монгол Улсын албадан хөдөлмөрийн эсрэг хууль тогтоомж, үндэсний бодлоготой харьцуулан шинжилсэн судалгааг монгол, англи хэлээр гүйцэтгэсэн. Үр дүн, жишээ: Судалгааны тайланг хоёр хэлээр боловсруулж, захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн. Олон улсын хөдөлмөрийн стандарт болон үндэсний эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог шинжлэх, хууль зүйн дүгнэлт боловсруулах чадварыг харуулна. Удирдсан албан тушаалтан: Олон улсын хөдөлмөрийн байгууллагын төслийн менежер А.Лхагвадэмбэрэл у **2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн ялын бодлогын судалгааг гүйцэтгэсэн.** Хугацаа: 2025 он Эрхэлсэн газар: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны захиалгаар Үйл ажиллагааны гол агуулга: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн ялын бодлогыг судалж, эрүүгийн эрх зүйн зохицуулалт, ялын бодлогын асуудлыг шинжилсэн. Үр дүн, жишээ: Судалгааны ажлыг гүйцэтгэж, захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн. Эрүүгийн эрх зүй, гэмт хэргийн бодлого, ял шийтгэлийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх мэргэжлийн чадварыг харуулна. Удирдсан албан тушаалтан: ГХУСАЗЗАА

		3. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах Хугацаа: 2024 он Эрхэлсэн газар: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны захиалгаар, Азийн сангийн санхүүжилтээр Үйл ажиллагааны гол агуулга: Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр (2025–2030 он) болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлыг гүйцэтгэн, багийг ахалсан. Үр дүн, жишээ: Хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг 2024 оны 12 дугаар сард боловсруулж хүлээлгэн өгсөн бөгөөд төслийн талаар танилцуулга хийсэн. Удирдсан албан тушаалтан: ГХУСАЗЗАА Эх сурвалж: Үндэсний хөтөлбөр, гэрээ дүгнэсэн акт. **4. Хууль сахиулах байгууллагын хүний нөөцийн удирдлага дахь хүний эрх, жендэрийн нөхцөл байдлын шинжилгээний үндэсний зөвлөхөөр ажилласан.** Хугацаа: 2024 он Эрхэлсэн газар: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн захиалгаар, “Монгол Улсад хууль сахиулах үйл ажиллагаанд хүний эрх, жендэрийн тэгш байдлыг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд Үйл ажиллагааны гол агуулга: Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн удирдлага дахь хүний эрх, жендэрийн нөхцөл байдлыг судалж, шинжилгээ хийн, холбогдох албан тушаалтнуудад сургалт явуулсан, бодлогын тайлан, зөвлөмж хүргүүлсэн. Үр дүн, жишээ: Судалгааг гүйцэтгэж, цагдаагийн байгууллагын 150 гаруй албан хаагчдад гурван удаагийн сургалт явуулан, судалгааны үр дүнг нэгтгэсэн тайлан, зөвлөмжийг ЦЕГ, ШШГЕГ-т тус тус хүргүүлсэн. **5. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох олон улсын сайн туршлагын судалгааг гүйцэтгэсэн.** Хугацаа: 2024 он Эрхэлсэн газар: Хүйсийн тэгш эрхийн төв, Азийн сангийн санхүүжилтээр Үйл ажиллагааны гол агуулга: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, тэр дундаа насанд хүрээгүй хохирогчид нөхөн төлбөр олгох олон улсын сайн туршлагыг судалж, Монгол Улсад хэрэгжүүлэх боломжтой арга, хэлбэрийг тодорхойлон санал, зөвлөмж боловсруулах судалгааны багийг ахалсан. Үр дүн, жишээ: Судалгааны багийг ахалж, тайлангийн үр дүнг нийтэд танилцуулсан. Удирдсан албан тушаалтан: Г.Ганбаясгах ХТЭТ-ийн тэргүүн

		6. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах журмууд боловсруулсан. Хугацаа: 2023 он Эрхэлсэн газар: Хүйсийн тэгш эрхийн төвийн санхүүжилт, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Үйл ажиллагааны гол агуулга: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах журам; хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам; Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны журам боловсруулсан. Үр дүн, жишээ: Гурван журмын төслийг боловсруулсан бөгөөд тус журмууд 2023-2024 онд ХЗДХС-ын тушаалаар батлагдсан. Удирдсан албан тушаалтан: Э.Энхтуяа /ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийн газрын дарга-2023 он/ Эх сурвалж: 2024 онд батлагдсан 3 журмын линк https://cccp.gov.mn/newsm/282/48?utm_source=chatgpt.com https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960401473551&utm_source=chatgpt.com https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355372002191&utm_source=chatgpt.com **7. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх** Хугацаа: 2023 он Эрхэлсэн газар: Нээлттэй нийгэм форумын захиалгаар Үйл ажиллагааны гол агуулга: Эрүүгийн хуулийн 24.2, 24.3, 24.6 дугаар зүйлд заасан хүрээлэн буй орчны эсрэг зарим гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийсэн. Үр дүн, жишээ: Шүүхийн шийдвэрт хууль зүйн дүн шинжилгээ хийсэн судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Удирдсан албан тушаалтан: Ш.Хишигсүрэн /Нээлттэй нийгэм форумын менежер/ Эх сурвалж: Судалгааны тайлангийн хэвлэмэл товхимол **8. “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” бүтээлээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит шилдэг бүтээлийн уралдаанд шалгарсан.** Хугацаа: 2023 он Эрхэлсэн газар: ХЗДХЯ Үйл ажиллагааны гол агуулга: “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” бүтээлээрээ хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлагын онол, эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудлыг судлан шинжилсэн. Үр дүн, жишээ: Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит шилдэг бүтээл, илтгэл шалгаруулах, грант олгох төслийн уралдаанд тус бүтээл нь уралдааны шилдэг

		бүтээлийн төрөлд гуравдугаар байранд шалгарсан. Энэхүү амжилт нь түүний хууль зүйн салбар дахь өндөр мэдлэг, чадварыг харуулж байна. Эх сурвалж: “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” ном, шалгаруулалтын шийдвэр, өргөмжлөл буюу батламжийн хуулбар. https://www.facebook.com/share/p/1Dbc2r1Ng7/ **9. Хорихоос суллагдсан этгээдэд тавих хяналт бодлогын судалгааг гүйцэтгэсэн.** Хугацаа: 2020 он Эрхэлсэн газар: Нээлттэй нийгэм форумын захиалгаар Үйл ажиллагааны гол агуулга: Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх чиглэлээр харьцуулсан судалгааг гүйцэтгэж, хүний эрхийг дээдлэх, нийгмийг эрүүлжүүлэх Япон Улсын жишгийг судалсан. Үр дүн, жишээ: Бодлогын судалгааг гүйцэтгэж, судалгааны тайланг хэвлүүлсэн. Эх сурвалж: Бодлогын судалгааны тайлангийн хэвлэмэл товхимол. **10. “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” сэдвээр докторын зэрэг хамгаалсан.** Хугацаа: 2020 он Эрхэлсэн газар: Дотоод хэргийн их сургууль Үйл ажиллагааны гол агуулга: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онол, эрх зүйн үндэслэл, Монгол Улсын эрх зүйн зохицуулалт болон харьцуулсан эрх зүйн асуудлыг судалсан. Үр дүн, жишээ: 2020 онд хууль зүйн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан. Судалгаа нь эрүүгийн эрх зүйн онол, хууль тогтоомж, гадаад орны туршлагыг харьцуулан судалж, эрх зүйн асуудалд дүгнэлт хийх мэргэжлийн өндөр чадварыг нотолно. Удирдсан албан тушаалтан: Г.Гантөмөр доктор, профессор Эх сурвалж: Докторын дипломын хуулбар
10	**Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил** Хүсэлт гаргагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: - албан тушаалын нэр, ажлын газрын	**1. Хүний эрхийн боловсрол, сургалт, мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр Хууль зүйн их сургуулийн захирлаар ажилласан.** Хугацаа: 2019 он- одоог хүртэл Албан тушаалын нэр: Хууль зүйн сургуулийн захирал - СИТИ Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирлаар ажиллах хугацаандаа сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг удирдан зохион байгуулж, хүний эрх, жендэрийн тэгш байдал, шударга ёс, эрх зүйн засаглалын зарчимд суурилсан хууль зүйн боловсролыг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Тухайлбал, эрх зүйн бакалавр, магистрын хөтөлбөрт “Хүний эрх” хичээлийг

	хаяг, ажилласан хугацаа; - ажлын байрны тодорхойлолт; - удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; - хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.	зургаа дахь жилдээ зааж, хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах мэдлэг, хандлага, ур чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд хувь нэмэр оруулж байна. Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл: СИТИ Их сургуулийн Сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга, Сургалт эрхэлсэн захирал Ц.Дамдинсүрэн Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажилладаг хүний нэр, холбоо барих мэдээлэл: Д.Булган Хууль зүйн сургуулийн багш **2. Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн өмгөөлөгч** Хугацаа: 2005 он- одоог хүртэл Албан тушаалын нэр: МӨХ-ны гишүүн өмгөөлөгч Ажлын байрны тодорхойлолт: Өмгөөлөгчөөр ажиллах хугацаандаа хүний үндсэн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хууль зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа тасралтгүй эрхэлж ирсэн. - Энэ хүрээнд эрүүгийн болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хамгаалах, хохирогч болон эрх нь зөрчигдсөн иргэдэд хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, шударга шүүхээр шүүлгэх болон өмгөөлүүлэх эрхийн хэрэгжилтийг хангах, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэсэн өмгөөллийн үйл ажиллагаа явуулж ирсэн. Мөн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах зарчмыг практикт хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулан ажилласан. Хамтран ажиллаж байсан өмгөөлөгчийн нэр, холбоо барих мэдээлэл: өмгөөлөгч Д.Чинзориг, өмгөөлөгч С.Гангантөгс **3. Хүний эрхийн судалгаа, бодлогын шинжилгээ, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил 10 жил гүйцэтгэсэн.** Хугацаа: 2005–2015 он Албан тушаал: Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан, бодлогын ахлах судлаач Ажлын газрын хаяг: Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо 7 дугаар хороолол /14182/ Алтайн гудамж 841 - ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, бодлогын ахлах судлаачаар ажиллах хугацаандаа Эрүүгийн эрх зүй, криминологийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийж, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хүний эрх, хүүхэд хамгаалал, гэмт хэргийн хохирогчийн эрх, хууль зүйн туслалцаа, хорихоос суллагдсан хүнийг нийгэмшүүлэх

		асуудалтай холбоотой судалгааны ажлууд нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хүний эрхийг хамгаалах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэж байв. Судалгаанаас дурдвал: - “Хүүхдийн эрхийн загвар хорооны дүрэм гаргах нь”, “Цагдан хорих байрны дотоод журам тогтоох нь” сэдэвт 2 судалгааг 2008 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн захиалгаар багаар хийж гүйцэтгэсэн. - 2008 онд “Шилжилт хөдөлгөөнийг боловсронгуй болгох асуудал” судалгааг НҮБ-ын Хүүхдийн сангийн захиалгаар хийж тайланг хүргүүлсэн. - Хүйсийн тэгш эрхийн төвөөс захиалсан “Хүний наймаа буюу хүн худалдах гэмт хэрэг Монгол Улсад” судалгааг 2007 онд багаар хийж гүйцэтгэсэн. Судалгааны тайлангийн хэвлэмэл товхимлыг хавсаргав. Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл: ХЗҮХ-ийн захирал, академич Ж.Амарсанаа Хамтран ажиллаж байсан хүний нэр, холбоо барих мэдээлэл: Д.Цэцэгдарь /ХЗҮХ-ийн ажилтан/ Х.Наранцацрал ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан
11	Хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг байдал Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд: - үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; - үйл ажиллагааны гол агуулга; - үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; - үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; - хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; - хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.	Хүний эрх, эрх чөлөө, хүний нэр төр, тэгш байдлыг эрхэмлэн, хүүхэд, эмэгтэйчүүд, хохирогч, хорих байгууллагад байгаа иргэд, ахмад настны эрхийг хамгаалах чиглэлээр судалгаа, бодлого, эрх зүйн зохицуулалт, сургалт, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, хүний эрхийн эрх зүйн болон институцийн баталгааг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж ирсэн.Эдгээрээс голлох 10 үйл ажиллагаа нь: **1. “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” сэдвээр нийслэлийн 9 дүүргийн ЕБС-ийн сурагчдад сургалт зохион байгуулах** Хугацаа: 2026 он Үйл ажиллагааны гол агуулга: Хүүхдийн оролцоо, манлайлалд тулгуурлан үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл, үл хайхрах байдлаас урьдчилан сэргийлэх, хүүхэд хүүхдээ хамгаалах хандлага, соёлыг төлөвшүүлэх Үйл ажиллагааны үр дүн: Амгалан айл ТББ, 108 хүүхдийн шуурхай тусламж, хамгааллын төв, Нийслэлийн 9 дүүргийн хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэсүүдтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн “Ангийн дарга” нарт зориулсан сургалтын хүрээнд “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” сэдвээр нийслэлийн 9 дүүрэгт сургалт зохион байгуулж, соён гэгээрүүлэх ажлыг түгээсэн. Хамтран ажиллаж байсан хүний нэр: Амгалан айл ТББ-ын гүйцэтгэх захирал О.Сарантуяа 88029845 Эх сурвалж: https://www.facebook.com/share/p/19kiyWLy8g/ **2. “Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны конвенцын 2014 оны протоколыг Монгол Улсын албадан хөдөлмөрийн эсрэг хууль, үндэсний**

		бодлоготой харьцуулсан шинжилгээ”-ний үндэсний зөвлөхөөр ажилласан. Хугацаа: 2025 он Үйл ажиллагааны гол агуулга: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар, ОУХБ-ын санхүүжилтээр “Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны конвенцын 2014 оны протоколыг Монгол Улсын албадан хөдөлмөрийн эсрэг хууль, үндэсний бодлоготой харьцуулсан шинжилгээ” харьцуулсан судалгааг англи, монгол хэл дээр хийж, тайланг хүлээлгэн өгсөн. Эх сурвалж: https://www.facebook.com/share/p/1E61FWvArb/ Үндэсний зөвлөхөөр ажиллах гэрээг хавсаргав. 3. **“Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр /2025-2030/, төлөвлөгөөг боловсруулсан.** Хугацаа: 2024 он Үйл ажиллагааны гол агуулга: ГХУСАЗЗАА-ны захиалга, Азийн сангийн санхүүжилтээр “Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр /2025-2030/, төлөвлөгөөг боловсруулж, Үйл ажиллагааны үр дүн: Хөтөлбөрийн төслийг 2024 оны 12 сард ГХУСАЗЗАА-нд хүлээлгэн өгч, танилцуулга хийсэн. Эх сурвалж: https://www.facebook.com/share/p/1EGrb7KYw8/ 4. **“Хууль ба жендэр” улсын хэмжээний эрдэм шинжилгээний бага хуралд “Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, чиглүүлэгчээр ажиллав.** Хугацаа: 2025 он Үйл ажиллагааны агуулга: Жендэрийн Үндэсний Хорооноос зохион байгуулсан “Хууль ба жендэр” улсын хэмжээний эрдэм шинжилгээний бага хуралд “Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлэхийн зэрэгцээ эрдэм шинжилгээний хурлын 2 дугаар хэсгийг чиглүүлж, модератороор ажиллав. Хамтран ажилласан хүн, холбоо барих мэдээлэл: Жендэрийн үндэсний хорооны мэргэжилтэн О.Буянаа Эх сурвалж: https://www.facebook.com/share/p/19Lyhhq2ZV/ 5. **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, насанд хүрээгүй хохирогчид нөхөн төлбөр олгох талаар олон улсын сайн туршлагыг судалж, өөрийн улсад хэрэгжүүлэх зохистой арга, хэлбэрийг тодорхойлох, санал зөвлөмж боловсруулах” судалгааны ажил гүйцэтгэх** Хугацаа: 2024 он Үйл ажиллагааны гол агуулга: 2024 онд Хүйсийн тэгш эрхийн төв болон Азийн сангийн санхүүжилтээр “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, насанд хүрээгүй хохирогчид нөхөн төлбөр олгох талаар олон улсын сайн туршлагыг

		судалж, өөрийн улсад хэрэгжүүлэх зохистой арга, хэлбэрийг тодорхойлох, санал зөвлөмж боловсруулах” судалгааны ажлын багийг ахалж, тайлангийн үр дүнг нийтэд танилцуулсан. Үйл ажиллагааны үр дүн: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нөхөн төлбөр авах эрхийг хангах эрх зүйн болон бодлогын орчныг боловсронгуй болгоход судалгааны хувь нэмэр оруулсан. Хамтран ажиллаж байсан хүний нэр, холбоо барих мэдээлэл: Хүйсийн тэгш эрх төв ТББ-ын тэргүүн Г.Ганбаясгах Эх сурвалж: https://stoptrafficking.mn/post/159994 **6. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн холбогдох журмуудыг боловсруулсан.** Хугацаа: 2023 он Үйл ажиллагааны гол агуулга: Хүйсийн тэгш эрхийн төвийн санхүүжилт, ХЗДХЯ-ны захиалгаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах журам”, “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хамгаалах байрны журам”-ыг боловсруулсан. Үйл ажиллагааны үр дүн: 2023-2024 онд тус 3 журам батлагдсан. Эх сурвалж: “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2024 оны А/60, А/40 дугаар хамтарсан тушаал https://cccp.gov.mn/newsm/282/48?utm_source=chatgpt.com “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/399 дүгээр тушаал. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960401473551&utm_source=chatgpt.com “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журам” Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 215 дугаар тогтоол https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355372002191&utm_source=chatgpt.com Хамтран ажиллаж байсан хүний нэр, холбоо барих мэдээлэл: Хүйсийн тэгш эрх төв ТББ-ын тэргүүн Г.Ганбаясгах **7. Хууль сахиулах байгууллагын хүний эрх, жендэрийн нөхцөл байдлын шинжилгээ хийсэн** Хугацаа: 2024 он Үйл ажиллагааны гол агуулга: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад хууль сахиулах үйл ажиллагаанд хүний эрх, жендэрийн тэгш байдлыг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд Хууль сахиулах байгууллагын хүний нөөцийн удирдлага дахь хүний эрх, жендэрийн нөхцөл байдалд дүн

		шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудал, сайжруулах шаардлагатай чиглэлийг тодорхойлох судалгааны ажил гүйцэтгэсэн. Үйл ажиллагааны үр дүн: Судалгааны үр дүнг танилцуулах, хүний эрх, жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор цагдаагийн 150 гаруй алба хаагчдад гурван удаагийн сургалт явуулсан. **8. Хорих байгууллагад ном хандивлах, хүний эрхийг дэмжих хамтын ажиллагаа хэрэгжүүлсэн.** Хугацаа: 2024 оноос Үйл ажиллагааны гол агуулга: Хорих байгууллагад байгаа хүмүүсийн ном унших, мэдлэг боловсролоо дээшлүүлэх боломжийг дэмжих, нийгэмшүүлэх үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах зорилгоор 441 дүгээр хорих ангитай хамтран ажилладаг. Үйл ажиллагааны үр дүн: Хамтын ажиллагааны хүрээнд нийт хоёр удаа 500 гаруй ном хандивлаж, алба хаагчдад сургалт орсон. Энэхүү ажил нь хорих байгууллагад байгаа хүмүүсийн боловсрол, мэдлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүний нэр төр, эрхийг хүндэтгэх хандлагыг дэмжихэд чиглэсэн. Хамтран ажиллаж байсан хүний нэр: 441 дүгээр хорих ангийн дарга, дэд хурандаа А.Сайнбилэг Эх сурвалж: https://www.facebook.com/share/p/1Dbc2r1Ng7/ **9. Ахмад настны эрх, сайн сайхан байдлыг дэмжих “Ахмадаа халамжлая” аян хэрэгжүүлсэн.** Хугацаа: 2023 оноос хойш Үйл ажиллагааны гол агуулга: “Ахмадаа халамжлая” хандивын аяны хүрээнд “Жаргалан эдлэн” ахмадын асрамжийн газарт хувцас, хүнс, шаардлагатай эд хэрэгслийн тусламж үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, ахмад настны эрхийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллаж байна. Үйл ажиллагааны үр дүн: Энэхүү үйл ажиллагаа нь ахмад настны нэр төр, эрх, сайн сайхан байдлыг хүндэтгэх, нийгмийн халамж, дэмжлэгийн ач холбогдлыг олон нийтэд таниулахад чиглэсэн. Хамтран ажилласан хүн: “Жаргалан эдлэн” ТББ Эх сурвалж: https://www.facebook.com/share/p/1F2c8fQ2Vj/ **10. Эрх зүйн боловсролд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах сургалтын модуль боловсруулах** Хугацаа: 2020 он Үйл ажиллагааны гол агуулга: Жендэрийн үндэсний хорооны ажлын хэсэгт ажиллаж, эрх зүйн сургалтын хөтөлбөрт жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах хүрээнд эрүүгийн эрх зүй, зөрчлийн эрх зүй, криминологи, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээний сургалтын модуль боловсруулсан.

		Үйл ажиллагааны үр дүн: Хууль зүйн их дээд сургуулиудад хүргүүлж, сургалтын төлөвлөгөөнд хүний эрх, жендэрийн асуудлыг тусгах ажил хийгдсэн. Хамтран ажиллаж байсан хүний нэр, холбоо барих мэдээлэл: Жендэрийн үндэсний хорооны мэргэжилтэн О.Буянаа Эх сурвалж: https://www.facebook.com/share/p/1F3N2vcF97/
12	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд: - албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; - ажлын байрны тодорхойлолт; - удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; - хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. Жич: Энэ зүйл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй.	
13	**Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар** Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ. - Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ.	**1. Монголын Хуульчдын холбоо** 2005 оноос Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульчаар ажиллаж байна. 2022 онд “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” сэдвээр сургалтын багц цагийн хөтөлбөрөө тус холбоогоор магадлан итгэмжлүүлж, холбооны сургагч багшаар томилогдон 2022, 2023, 2024 онуудад хуульчдад зориулсан кредит цагийн сургалт явуулсан. **2. Монголын Өмгөөлөгчдийн холбоо**

	Гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгосон бол энэ талаар бичиж, шалтгааныг тайлбарлана. - Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ.	2005 оноос Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгчөөр ажиллаж байна. 2015–2019 онд төрийн жинхэнэ алба эрхэлж байсан хугацаанд өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхээ түдгэлзүүлсэн. Төрийн жинхэнэ алба эрхэлж байсан шалтгаанаар уг хугацаанд гишүүнчлэл, мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой эрхээ түдгэлзүүлсэн бөгөөд 2019 оноос хойш үргэлжлүүлэн ажиллаж хүний эрхийг хамгаалж байна.
14	Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл - Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ. - Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн эсхүл бэлдэхэд оролцсон хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ. - Лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол бичнэ. Хэрэв хуулбар хийх боломжгүй бол зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ. - Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагын огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө. Жич: Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана.	1**. Хүний эрх, хүүхдийн эрх, жендэрийн тэгш байдал, хохирогчийн эрхийг хамгаалах чиг,лэлээр боловсруулсан судалгаа, тайлан, журам, зөвлөмж** 1.1. “Хүүхдийн эрхийн загвар хорооны дүрэм гаргах нь” судалгаа Огноо: 2008 он Захиалагч байгууллага: НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF) Оролцоо: Судалгааны багийн гишүүн Гол агуулга: Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн эрхийн хэрэгжилтийг орон нутгийн түвшинд дэмжих загвар хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын санал боловсруулах. 1.2. “Цагдан хорих байрны дотоод журам тогтоох нь” судалгаа Огноо: 2008 он Захиалагч байгууллага: НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF) Оролцоо: Судалгааны багийн гишүүн Гол агуулга: Цагдан хорих байрны үйл ажиллагааны дотоод журам, эрх зүйн зохицуулалтыг судалж, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр санал боловсруулах. 1.3. “Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь” судалгааны тайлан Огноо: 2020 он Захиалагч байгууллага: Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO) Оролцоо: Олон улсын зөвлөхтэй хамтран дотоодын зөвлөх судлаач, судалгааны багийн ахлагчаар ажилласан. Гол агуулга: Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх хууль тогтоомж болон түүний хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлж, эрх зүйн зохицуулалт, практикийг сайжруулах санал дэвшүүлсэн. Судалгааны тайлан хэвлэгдсэн. 1.4. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг эрх зүйн сургалтын агуулгад тусгах сургалтын модуль

		Огноо: 2020 он Зохион байгуулагч байгууллага: Жендэрийн үндэсний хороо Оролцоо: Ажлын хэсгийн гишүүн Гол агуулга: Эрх зүйч бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын агуулгад жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах хүрээнд эрүүгийн эрх зүй, зөрчлийн эрх зүй, криминологи, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээний хичээлүүдийн сургалтын модуль боловсруулсан. 1.5. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах журмууд Боловсруулсан огноо: 2023 он Захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам Санхүүжилт: Хүйсийн тэгш эрхийн төв Оролцоо: Журам боловсруулах ажилд оролцсон. Боловсруулсан баримт бичиг: “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2024 оны А/60, А/40 дугаар хамтарсан тушаал https://cccp.gov.mn/newsm/282/48?utm_source=chatgpt.com “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/399 дүгээр тушаал. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960401473551&utm_source=chatgpt.com “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журам” Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 215 дугаар тогтоол https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355372002191&utm_source=chatgpt.com Гол агуулга: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах боломжийг бүрдүүлэх, хамгаалах байрны үйлчилгээний эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад чиглэсэн. 1.6. “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, насанд хүрээгүй хохирогчид нөхөн төлбөр олгох талаар олон улсын сайн туршлагыг судалж, өөрийн улсад хэрэгжүүлэх зохистой арга, хэлбэрийг тодорхойлох, санал зөвлөмж боловсруулах” судалгаа Огноо: 2024 он Хамтран ажилласан байгууллага: Хүйсийн тэгш эрхийн төв, Азийн сан Оролцоо: Судалгааны багийн ахлагч Гол агуулга: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, тэр дундаа насанд хүрээгүй хохирогчид нөхөн төлбөр олгох олон улсын сайн туршлагыг судалж, Монгол Улсад

		хэрэгжүүлэх боломжтой арга хэлбэр болон санал, зөвлөмж боловсруулсан. Судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулсан. 1.7. “Монгол Улсад хууль сахиулах үйл ажиллагаанд хүний эрх, жендэрийн тэгш байдлыг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд хийсэн нөхцөл байдлын шинжилгээ Огноо: 2024 он Захиалагч байгууллага: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) Оролцоо: Судалгааг гүйцэтгэж, үр дүнг танилцуулсан. Гол агуулга: Цагдаа болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүрээнд хууль сахиулах байгууллагын хүний нөөцийн удирдлага дахь хүний эрх, жендэрийн нөхцөл байдлыг шинжилсэн. Судалгааны үр дүнтэй холбогдуулан цагдаагийн байгууллагын 150 гаруй алба хаагчдад гурван удаагийн сургалт зохион байгуулж, үр дүнг танилцуулсан. 1.8. “Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр (2025–2030), төлөвлөгөө” Боловсруулсан огноо: 2024 он Захиалагч: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба Санхүүжилт: Азийн сан Оролцоо: Хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах багийн ахлахаар ажилласан. Гол агуулга: Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2025–2030 онд хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний төслийг боловсруулж, 2024 оны 12 дугаар сард хүлээлгэн өгч, танилцуулсан. 1.9. “Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны конвенцын 2014 оны протоколыг Монгол Улсын албадан хөдөлмөрийн эсрэг хууль, үндэсний бодлоготой харьцуулсан шинжилгээ” Огноо: 2025 он Захиалагч байгууллага: Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ) Оролцоо: Харьцуулсан судалгааг монгол, англи хэлээр гүйцэтгэж, тайлан хүлээлгэн өгсөн. Гол агуулга: Олон улсын хөдөлмөрийн стандарт болон Монгол Улсын албадан хөдөлмөрийн эсрэг хууль тогтоомж, үндэсний бодлогын уялдаа холбоог харьцуулан шинжилсэн. **2. Хүний эрх, хууль зүйн туслалцаа, хүүхдийн эрхтэй холбоотой хэвлүүлсэн бүтээл, өгүүлэл** 2.1. “Монгол Улсад үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн асуудал” Огноо: 2009 он

		Хэвлэгдсэн газар: Улаанбаатар Пресс Хамтран зохиогч: Г. Оюунболд, Д. Тамир Гол агуулга: Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн асуудлыг судалсан бүтээл. 2.2. “Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэхэд олон нийтийн оролцоо чухал болох нь” Огноо: 2014 он Хэвлэгдсэн газар: “Шүүх эрх мэдэл” сэтгүүл, 2014 оны № 4 Гол агуулга: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд олон нийтийн оролцоо, дэмжлэгийн ач холбогдлыг авч үзсэн. 2.3. “Монгол Улсад төлбөрийн чадваргүй этгээдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал” судалгаа Огноо: 2017 он Захиалагч байгууллага: Нээлттэй нийгэм форум Оролцоо: Судалгааг бие даан гүйцэтгэсэн. Гол агуулга: Төлбөрийн чадваргүй этгээдийн хууль зүйн туслалцаа авах боломж, холбогдох эрх зүйн зохицуулалтын асуудлыг судалсан. 2.4. “Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх бүхий этгээд, түүний төрөл” сэдэвт илтгэл Огноо: 2018 оны 4 дүгээр сарын 11 Зохион байгуулагч: Хууль зүйн туслалцааны төв Арга хэмжээ: Эрдэм шинжилгээний хурал Гол агуулга: Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх бүхий этгээд, тэдгээрийн ангилал, холбогдох эрх зүйн асуудлыг хэлэлцүүлсэн. 2.5. “Насанд хүрээгүй хүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох нь” Огноо: 2025 он Хэвлэгдсэн газар: “Гэмт явдалтай тэмцэх нь” сэтгүүл, 2025 оны № 3 Гол агуулга: Насанд хүрээгүй хүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн дээд ашиг, хүүхдийн эрхийг хамгаалах талаар эрх зүйн асуудлыг судалж, зөвлөмж боловсруулсан. **3. Хуульч, судлаач, олон нийтэд зориулан хэлэлцүүлсэн илтгэл, танилцуулга** **<u>Дотоодод:</u>** 3.1. “Шүүгчид нөлөөлөх хэлбэр, нөлөөллийн мэдүүлэг” Огноо: 2017 оны 11 дүгээр сарын 30

		Зохион байгуулагч: Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах хэлтэс Арга хэмжээ: “Шүүгчийн хараат бус байдал ба олон нийтийн хяналт” сэдэвт хэлэлцүүлэг Гол агуулга: Шүүгчийн хараат бус байдал, шүүгчид нөлөөлөх оролдлого болон нөлөөллийн мэдүүлэгтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлсэн. 3.2. “Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт” Огноо: 2020 оны 4 дүгээр сарын 22 Зохион байгуулагч: Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Хууль зүйн сургууль Арга хэмжээ: “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2050: Эрх зүйн шинэтгэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурал Гол агуулга: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтын асуудлыг танилцуулсан. 3.3. “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, насанд хүрээгүй хохирогчид нөхөн төлбөр олгох талаар олон улсын сайн туршлага” судалгааны үр дүнгийн танилцуулга Огноо: 2024 он Хамтран ажилласан байгууллага: Хүйсийн тэгш эрхийн төв, Азийн сан Оролцоо: Судалгааны багийн ахлагч Гол агуулга: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, насанд хүрээгүй хохирогчид нөхөн төлбөр олгох олон улсын туршлага, Монгол Улсад хэрэгжүүлэх боломжтой арга хэлбэр, санал зөвлөмжийг олон нийтэд танилцуулсан. **<u>Олон улсад:</u>** 3.4. БНСУ-ын Сэүл хотноо зохион байгуулсан Азийн Криминологичдын 4 дүгээр Их Хуралд “Монгол Улс дах авилгын гэмт явдал түүний шалтгаан нөхцөл” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлсэн. Огноо: 2012 он Оролцоо: Илтгэл англи хэл дээр хэлэлцүүлсэн. Гол агуулга: Авлигын гэмт явдлын шалтгаан, түүнийг бууруулах хүчин зүйлийн талаар судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн. 3.5. БНЭУ-ын Мумбай хотод зохион байгуулагдсан Азийн Криминологичдын 5 дугаар Их Хуралд “Насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлсэн. Огноо: 2013 он Оролцоо: Илтгэл англи хэл дээр хэлэлцүүлсэн.

		Гол агуулга: Насанд хүрээгүй хүний зүгээс үйлдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнийг бууруулах, хүүхдийн суурь эрхийг хангах асуудлаар илтгэл хэлэлцүүлсэн. 3.6. ХБНГУ-ын Макс Планкийн Гадаад болон Олон улсын эрүүгийн эрх зүйн институтид зохион байгуулсан олон улсын хамтарсан зөвлөгөөнд “The Issue on Improvement of Forced Labor Sentence of Mongolia and Enhancing the Effectiveness of the Sentence Based on Society” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн. Огноо: 2015 оны 11 сард Оролцоо: Илтгэлийг англи хэл дээр хэлэлцүүлсэн. Гол агуулга: Improvement of Forced Labor Sentence of Mongolia and Enhancing the Effectiveness of the Sentence Based on Society” буюу Монгол Улсад албадан хөдөлмөрлөх ялыг нийтэд тустай ажил хийлгэх ялаар сольж хүний эрхийг хангах талаар илтгэл хэлэлцүүлсэн.